

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ОПЕРАТИВЫН БАЙГУУЛАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ

Г.Содбаяр

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 8022 дугаар дамжааны суралцагч, хошууч

Товч агуулга: Хил хамгаалах байгууллага хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд хүний хүчинд тулгуурласан уламжлалт аргыг боловсронгуй болгон түүний орон зайг орчин үеийн дэвшилтэд техник, технологийн ололтод суурилсан эдийн засгийн хувьд үр ашигтай, хүний хөдөлмөрийг хөнгөвчилсөн шийдлийг ашиглах нь байгууллагын хөгжлийн үндсэн чиглэл болж байна.

Түлхүүр үгс: Оперативын байгууламж, инженер-техникийн хангалт, технологийн дэвшил

Оршил. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод дархан хил зорилт 7.2, I үе шат (2021-2030)-нд хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, бүсчилсэн хил хамгаалалтыг хөгжүүлэн цэргийн холбоо, зэвсэглэл, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх үе¹⁹⁷ гэж заасан байна.

Монгол Улсын хилийн тухай хуулийн дөрөвдүгээр бүлгийн 31.2 дахь заалтад Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, Монгол Улсын хилийн хууль тогтоомж, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор улсын хилийн зурвас, боомт, бүс, хил орчмын нутаг дэвсгэрт улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, цэргийн, инженер-техникийн, мэдээлэл технологийн, тагнуулын, хилийн төлөөлөгчийн арга

хэмжээг хослуулан явуулж байгаа үйл ажиллагааг улсын хил хамгаалалт гэнэ.

31.3 дахь заалтад Газар, усан дээрх улсын хилийг улсын хил хамгаалах байгууллага, агаарын хилийг зэвсэгт хүчний агаарын цэрэг хамгаална гэж тус тус заасан.¹⁹⁸

Судлаачдын хил хамгаалалтыг дээшлүүлэх, аюулгүй байдлыг сахин хамгаалах чиглэлээр олон бүтээлүүд байдаг ба түүн дотор техник, технологийг ашиглах талаар зарим нэг санаанууд орсон боловч, тухайн үеийн технологийн хөгжилд тулгуурласан тул орчин үеийн нөхцөл, шаардлагыг бүрэн хангахгүй байдал тулгаад байна.

Иймд “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан “Дархан хил” зорилт I үе шат (2021-2030) “Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, бүсчилсэн хил хамгаалалтыг хөгжүүлэн цэргийн холбоо, зэвсэглэл, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх

¹⁹⁷ “Алсын хараа 2050” хөтөлбөр. Засгийн газрын урт хугацааны хөгжлийн бодлого

¹⁹⁸ Монгол Улсын хилийн тухай хууль 2016 он.

үе”-д тусагдсан энэхүү сэдвийг судлах хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Улсын хил хамгаалалтын урлаг гэдгийг улсын хил дээр болон хилийн орон зайд төр, нийгэм, иргэдийн амин чухал эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн ажиллагааг бэлтгэх, явуулахтай холбогдсон онол практикийн цогц ойлголт юмаа¹⁹⁹.

Хил хамгаалалтын урлагийн салшгүй, туйлын чухал бүрэлдэхүүн хэсэг нь “Хилийн цэргийн оперативын урлаг” мөн.

Хилийн цэргийн оперативын урлаг: гэдэг нь Улсын хил дээр буюу хилийн орон зайд Монгол улсын улс төр, эдийн засаг, цэргийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хилийн цэргийн оперативын бүлгүүдийн (хилийн төлөөлөгчийн газрын) ажиллагааг бэлтгэх, явуулахтай холбогдсон онол, практикийн цогцолбор мөн.

Хилийн цэргийн оператив урлаг нь улсын хил хамгаалалтын урлагийн салшгүй, чухал хэсэг болохын хувьд тэрээр хилийн стратеги, хилийн цэргийн тактикийн завсарт холбогч үүрэг хүлээж стратегийн зорилтыг хэрэгжүүлэх, тактикийг төгөлдөржүүлэх, хил хамгаалалтын урлагийн онол, практикийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

Хилийн цэргийн оперативын урлаг нь онол, практикийн хоёр талт үйл ажиллагаа бөгөөд онолын хэсэгт хилийн цэргийн оперативын бүлгүүдээс явуулах хил хамгаалах үйл ажиллагааг шинжлэх ухааны үзэл баримтлалд үндэслэн боловсруулах, гарах үр дүнг дээшлүүлэх зорилтыг хэрэгжүүлдэг бол практик хэсэгт нь хилийн цэргийн оператив бодит үйл ажиллагаа, энэ үеийн удирдлага зохион

байгуулалтын болон цэргийг удирдах, бүх талаар хангах асуудлууд багтана.

Үйл ажиллагааны цэрэг-техникийн төрөл нь:

Улсын хил хамгаалалтын зорилтыг хэрэгжүүлэхээр цэргийн ажиллагааг инженер, зэвсэг, техникийн арга хэмжээтэй хослуулан явуулах цогцолбор ажиллагаа юм.

Хил хамгаалалтын оперативын бүлгүүдээс явуулах ажиллагааны үндсэн *хэлбэр* гэдгийг хилийн цэргийн гүйцэтгэж буй үүрэг зорилго, ажиллагааны шинж чанар, тухайн чиглэл дэх хилийн цэргийн оператив бүлгүүдийн боломж, үйл ажиллагааны масштабт нийцүүлэн хүч хэрэгслийг зохион байгуулалттайгаар хэрэглэх явдал гэж ойлгож болно.

Хилийн цэргийн оперативын бүлгүүдээс явуулах ажиллагаа нь дараах үндсэн аргуудаас бүрдэнэ. Үүнд:

- ✓ эрэл хайгуулын болон тагнуул-байлдааны арга;
- ✓ оператив-цэргийн ажиллагааны арга;
- ✓ агаарын нисэх хэрэгслийн хүчин чадлыг ашиглан явуулах арга (агаарын эрэл хайгуул, хаалт) г.м;
- ✓ давших болон хориглох арга;
- ✓ тодорхой чиглэлд хилийн салбаруудыг түр байгуулж, үе шат бүхий хяналт шалгалт явуулах арга;
- ✓ отолт болон дайралтын арга;
- ✓ эрэл байлдааны ажиллагааны арга;
- ✓ байлдааны хамгаалалтын арга;
- ✓ тусгай ажиллагааны арга;
- ✓ байлдааны жижүүрлэлтийн арга.

Дурдсан эдгээр аргуудыг хослуулан явуулж болно.

¹⁹⁹ хил судлалын шинжлэх ухаанынол практикийн зарим асуудал 2014

3.1.9. “улсын хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламж” гэж хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий саад, мөр хянах зурвас, зам, гүүр, хянах цамхаг, холбоо, дохиолол хяналтын техник хэрэгсэл, замын хаалт болон бусад байгууламжийг²⁰⁰.

26 дугаар зүйл. Улсын хилийн зурвас, түүнд мөрдөх журам, хориглох зүйл

26.1. Улсын хилийн дэглэмийг сахиулах, улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албыг зохион

Хил хамгаалалтын опертивын байгууламж гэх ойлголтыг энгийнээр тайлбарлавал.

байгуулах, хилийн инженер, техникийн байгууламж барих зориулалтаар улсын хилийн шугамаас дотогш 15 км-ээс илүүгүйгээр тусгай журам тогтоосон нутаг дэвсгэрийг улсын хилийн зурвас гэнэ²⁰¹.

36 дугаар зүйл. Улсын хил хамгаалах байгууллагын бүрэн эрх

36.1.2. улсын хил хамгаалалтын эрх ашгийн үүднээс хилийн зурвас, бүс, хил орчмын нутаг дэвсгэрт хүч хэрэгслээ байрлуулах, инженер, техникийн болон зам харилцааны байгууламж барьж байгуулах эрхтэй²⁰² гэж Монгол Улсын хилийн тухай хуульд тусган хуульчилсан.

Хүч хэрэгслэлийн бүлэглэл	Хамгаалалтын заагууд			Хилийн инженерийн байгууламж
	хил хамгаалалтын зааг	хил халхлалтын зааг	гүний зааг	
Бие бүрэлдэхүүн; Инженер, дохиолол-хяналтын хэрэгсэл; Мэдээлэл технологийн хэрэгсэл; Техник хэрэгсэл; Албаны амьтад; Хил хамгаалалтад туслах хүчин Хүч хэрэгсэл нь хилийн зөрчил гарч болзошгүй чиглэлийн заставт төвлөрсөн байх Хүч хэрэгслийн хуваарилалт (хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон хил орчмын	Улсын хилийн дэглэмийг сахиулах, улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албыг зохион байгуулах, хилийн инженер, техникийн байгууламж барих зориулалтаар улсын хилийн шугамаас дотогш 15 км-ээс илүүгүйгээр тусгай журам тогтоосон нутаг дэвсгэрийг улсын хилийн зурвас гэнэХЦБ-ын мэдээ	хил орчмын дэглэмийг сахиулах, хилийн зөрчлийг илрүүлэх, хил зөрчигч, хил зөрчихөөр завдсан үйлдлийг таслан зогсоох зорилгоор цагийн байдлын өрнөлт, газар орны нөхцөл байдлаас шалтгаалан тогтоож, инженер, дохиолол-	Хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тусгай журам тогтоосон нутаг дэвсгэрийг улсын хилийн бүс гэх бөгөөд түүний өргөнийг улсын хил хамгаалах байгууллага тухайн нэгжийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр улсын хилийн шугамаас 100 км-ээс илүүгүйгээр тогтооно. хил орчмын дэглэмийн	улсын хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламж” гэж хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий саад, мөр хянах зурвас, зам, гүүр, хянах цамхаг, холбоо,


²⁰⁰ Монгол Улсын хилийн тухай хууль 2016 он.

²⁰¹ Монгол Улсын хилийн тухай хууль 2016 он.

²⁰² Монгол Улсын хилийн тухай хууль 2016 он.

дэглэмийг сахиулахад шаардагдах хүч хэрэгсэл, Хамгаалалтын заагуудыг хүч хэрэгслээр халхлах Иргэнийг сайн дурын үндсэн дээр улсын хил хамгаалалтад татан оролцуулах; иргэдийг ажил, үйлдвэрлэл, нутаг дэвсгэрийн байрлалаар нь улсын хил хамгаалалтад туслах хүчин болгон зохион байгуулж, хил хамгаалалтад оролцуулах;	цуглуулах, зөрчлийн шинж тэмдэг илрүүлэх, хил зөрчлийн шинж тэмдгийг илрүүлэх, хил зөрчигчдийг хил давуулан буюу нутгийн гүнд алдахгүй байх зорилгоор хилийн шугамын дагуух газар орон дээр тогтоож, инженер, дохиолол- хяналтын хэрэгслээр төхөөрөмжилж, хилийн манаа, харуул, бүлгийн хүчээр хамгаална.	хяналтын хэрэгслээр төхөөрөмжлө н, заставын хүч хэрэгсэл, тагнуул, отрядын бэлтгэл хүч, хил хамгаалалтад туслах хүчний оролцоотойг оор хамгаална.	биелэлтийг сахиулах, хил зөрчигчийг эрэх, хил зөрчихөөр завдагсдыг илрүүлэх зорилгоор хилийн бүсээр тогтоож, бэлтгэл хүч, тагнуул, гүйцэтгэх ажлын хүч хэрэгсэл, хил хамгаалалтад туслах хүчин болон харилцан ажиллагаатай байгууллагуудын оролцоотойгоор хамгаална. Улсын хилийн бүсэд мөрдөх журмын биелэлтэд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага улсын хил хамгаалах байгууллагатай хамтран хяналт тавина	дохиолол хяналтын техник хэрэгсэл, замын хаалт болон бусад байгууламжийг ; улсын хил хамгаалалтын эрх ашгийн үүднээс хилийн зурвас, бүс, хил орчмын нутаг дэвсгэрт хүч хэрэгслээ байрлуулах, инженер, техникийн болон зам харилцааны байгууламж барьж байгуулах
---	---	---	---	--

Эдгээрээс явуулж байгаа цогц арга хэмжээг хил хамгаалалтын байгууламж гэж ойлгож болно.



Улсын хил хамгаалалт нь *тасралтгүй, гүнтэй, хүч хэрэгслээ болзошгүй чиглэлд төвлөрүүлэх, нууц далд, гэнэт, харилцан ажиллагаатай байх* зэрэг үндсэн зарчмаар явагдана.

Улсын хил хамгаалалтын **гол зорилго нь** улсын хилийн шугамын явалтыг газар орон дээр хууль бусаар өөрчлүүлэхгүй байх, улсын хилийн дэглэм, хил орчмын дэглэм, хилийн боомтын журмыг хуулийн этгээдүүдээр хүндэтгэн сахиулах явдал мөн.

Улсын хил хамгаалалтын талаар авч буй арга хэмжээнүүдийг **хил хамгаалалтын арга хэмжээнүүд** гэж томъёолох нь зүйтэй юм. Хувь хүн, нийгэм, төрийн амин чухал эрх ашигт учруулах аюул заналыг зайлуулахад чиглэсэн улсын нэгдсэн бодлогын хүрээнд хийгдэж буй арга хэмжээний чухал бүрэлдэхүүн хэсэг нь хил хамгаалалтын арга хэмжээ юм.

Улсын хил хамгаалалтын үйл явцын байнга тогтмол давтагдаж байдаг хүч хэрэгслийн ажиллагааны (үзэгдлийн) шалтгаан-үр дагаврын хууль, зүй тогтлыг илрүүлэх явдал нь бодит зүйл юм. Тэдгээр нь улсын геополитикийн байршил, нутаг дэвсгэрийн хэмжээ, хил залгаа улсууд гэх мэтээс хамаарахгүй үйлчилдэг. Иймд дэлхийн ямар ч улс нь өөрийн хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаагаа зохион байгуулан явуулахдаа эдгээрт тулгуурладаг байна.

Улсын хил хамгаалалт нь нийгмийн амьдралын бүхий л салбартай салшгүй холбоотой, тусгаар улсын бодит хэрэгцээ, онцгой ач холбогдолтой үйл ажиллагааны цогц мөн бөгөөд судалгааны объект, судлах

зүйлтэй байгаагаараа онолын шинжийг агуулдаг. Энэ утгаар авч үзвэл улсын хил хамгаалалт нь бие даасан онол буюу шинжлэх ухааны мэдлэгийн тусгай салбар гэж үзэж болно.

Хил хамгаалах байгууллагаас авч хэрэгжүүлж буй олон талт арга хэмжээнүүд нь зөвхөн “*эсрэг тал*”-ын сөрөг үйлдэл, “*өөрийн талын*” боломж, хүч хэрэгслийг тооцоод зогсохгүй, дээр дурдсан үйл ажиллагааныхаа орчинг зайлшгүй үнэлж цэгнэж байх нь тун чухал болохыг дахин анхааруулахын зэрэгцээ дурдсан “*орчин*”-ууд манай эсрэг талд илүү боломж олгож байгаа, эсвэл тэдэнд ашиглуулж болох бидний нэрлэж заншсан “*цоорхой*” байгаа эсэх, энэ цоорхойг хэрхэн нөхөх, эсвэл өөрийн үйл ажиллагааг амжилтанд хүргэхэд дурдсан орчнуудаас аль орчныг нь ашиглах, эсвэл нөгөөх л сөрөг нөлөөлөл үзүүлэх “*цоорхойг*” хэрхэн арилгах талаар тодорхой, цэгцтэй үйл ажиллагаа явуулахыг шаарддаг байна.

Улсын хил хамгаалалт нь олон улсын жишгээр, дээрх орчнуудад тохирсон өөрийн хүч хэрэгслээр үйл ажиллагаа явуулах бие даасан **хилийн албаны, алба-байлдааны, оперативын, эрэл-хайгуулын, тагнуулын, сөрөг тагнуулын, оператив-тактикийн, эрүү-мөрдөнгийн, захиргаа-эрх зүйн, хилийн төлөөлөгчийн** гэх мэт арга хэлбэрүүдтэй байдаг байна.

Хилийн инженерийн төхөөрөмжлөлтийн байдал. Дэлхийн улс бүхэн тэр дотроос Монгол Улс хилийн шугамын дагуу техникийн төхөөрөмжлөлт хийхийг чухалд үздэг.

Энэ дотроос инженерийн төхөөрөмжлөлт нь онцгой байр эзэлдэг. Улсын хилийн дагуу инженерийн төхөөрөмж хийснээр улсын хил энд байна гэдгийг бүх нийтээр мэдэх, нөгөө талаар улсын хилийг дур мэдэн өөрчлөх, зөрчихгүй байх үүднээс хилийн шугамын дагуу инженерийн байгууламж, саад, хаалт барьж байгуулдаг. Энэ нь улсын хил манах үр ашгийг дээшлүүлэхэд чиглэгдсэн олон төрлийн арга хэмжээний цогц юм. Инженерийн байгууламжид хилийн тэмдэг, багана, хилийн дагуух мөр хяналтын зурвас, төрөл бүрийн саадууд, хяналтын байрууд, зам, харгуй, нисэх онгоц, нисдэг тэрэгний хөөрөх, буух талбай, усан хилийн хөнгөн хөлөг онгоцны зогсоол, худаг ус, хилийн манааны дулаацах байр, машин техник, радиолокацийн станцийн далдлагдсан байрууд зэрэг ордог. Хэрэв инженер-техникийн хангалт байхгүй бол улсын хил зөрчигчид задгайрч тэднийг барьж саатуулалгүй алдах аюултай. Тухайлбал улсын хилээр хууль бусаар нэвтэрсэн этгээдийг нутгийн гүнд хэдэн зуун километрийн зайнд алдах эсвэл дотоодоос гарах зорилготой этгээдийг саатуулж чадалгүй гадагш алдах болно.

Хэрэв инженер-техникийн байгууламж саадыг системтэй байгуулж боловсронгуй болгож чадвал улсын хил зөрчигч этгээдийг 1-30 км-ийн зайд барих боломж бүрдэнэ.

Өнөөгийн байдлаар Монгол улсын хилийн 26,2 хувийг хамарсан 2169,5 км урт өргөст торон хашааг ашиглаж байгаагийн дотор 49,2 хувь нь

өмнөд хил дээр 16,3 хувь нь умард чиглэлд байна. Өөрөөр хэлбэл улсын хилийн ихэнх хэсэгт ямар нэг инженерийн саад баригдаагүй гэсэн үг. Мөн хилийн дагуу өнгөрсөн хугацаанд 3526,6 км мөр шалгах зурвас ашиглаж байсан бол өнөөгийн байдлаар 1370,6 км буюу Монгол улсын хилийн 16,6 хувийг хамардаг болж буурчээ. Улсын хилийн дагуу 73,0 хувьд нь мөр шалгах ийм зурвас татагдаагүй, одоогийн байгааг нь борнойдох зэргээр байнгын ашиглалтад байлгаж чадахгүй байна. Одоо улсын хил дээр 377 хянах байр байгаа ба нэг хянах байрт дунджаар 21,8 км хэсэг оногдож байгаа юм. ХЦ-ийг дахин байгуулагдсан үе 1967 оноос эхлэн хилийн заставын барилга байгууламжийн тоо 150, хөрөнгө оруулалтын хэмжээ 93, техникийн тоо 36 дахин нэмэгдсэн байна. Өмнөд хилийн дагууд заставт дунджаар 1-2 төмөр хянах цамхаг, 3400 км МХЗ, 2200 км гаруй өргөс утсан хашаа, 36 км цахилгаан дохиоллын систем, 224 ш кристалл багаж, прожекторын станц-34, радиолокацийн станц-17, заставын тулгуурт байр-75, отрядын хориглолтын район-10, хилийн районд нийт замын сүлжээний урт 4932 км хүрч нийт уртаараа 581 погонметр гүүрийг барьж байгуулан хил хамгаалалтын эрх ашигт нийцүүлэн ашиглаж байжээ” гэж доктор Д.Нямдорж өөрийнхөө судалгааны

ажилд дурдсан байдаг²⁰³. Харамсалтай нь дээрх байгууламжуудаас өнөөдрийн байдлаар цөөн тооны хянах цамхаг,

хэдхэн км МХЗ, өргөст утсан хашаа үлдсэнийг эс тооцвол бараг байхгүй гэж хэлж болохоор

д/д	Байгууламжийн нэр	Монгол-Хятадын хилд	Монгол-Оросын хилд	Үүнээс ашиглагдаж байгаа	Ашиглалтын хувь
1	Өргөст утсан хашаа	2318,6 км	578,2 км	2169,5	93,7
2	Мөр хянах зурвас	3379 км	147,6 км	1370,6	40,5
3	Хянах манааны байр	216	161	377	100,0
4	Хянах цамхаг	65	50	83	72,5
5	Дохиоллын систем	12 км	-	-	-
6	Модон болон төмөр бетон гүүр	15	23	36	94,7
7	Агаарын баганат шугам	2184,5 км	507,5 км	2692	100,0
8	Холбооны кабель шугам	140,863 км	18,88 км	160,7	99,0

Тэр дотроо техникийн харуул, техникээр хил хамгаалахтай холбоотой бүх төхөөрөмжүүд, тийм төрлийн техник хэрэгслүүд, хилийн отрядуудад байсан инженерийн мэргэжлийн офицерууд, тусгай салаа, тухайн ангийн орон тооны бүтцээс үндсэндээ хасагдаж одоо хилийн отрядуудад энэ албыг мэргэжлийн бус офицерууд ёс төдий хавсран гүйцэтгэх болжээ. Хилийн отрядуудад 2011 онд зэвсэг, техникийн албаны офицерууд \инженерийн албыг хавсран гүйцэтгэж байгаа\-ын дунд явуулсан судалгаанд нийт 27 офицер оролцсоноос мэргэжлийн чиглэлийн нэг ч хүнгүй, 2-3 жил ажиллаж байгаа хүн 15 хувь, бусад нь бүгд 1-2 жил ажиллаж байгаа бөгөөд инженерийн албаны ажил үүргийг талаар ямар ч мэдлэг, ойлголтгүй байгаа нь харагдаж байна.

Улсын хил хамгаалалтын инженер-техникийн арга хэмжээ нь улсын хил хамгаалалтын найдвартай байдлыг хангах үндсэн чиг үүргийг эдийн засгийн хувьд хамгийн үр ашигтайгаар, хүч хэрэгслийн хувьд хамгийн хэмнэлттэйгээр, илрүүлэлтийн магадлалын хувьд бараг 1.0 байхуйц хэмжээнд биелүүлэх боломж олгодог арга хэмжээ бөгөөд орчин үед маш өндөр хурдтайгаар хөгжин, улам бүр боловсронгуй болж буй хил хамгаалалтын хамгийн ирээдүйтэй хэлбэр болж байна.

Улсын хилийн инженер-техникийн хангалт⁵ гэж- Техникийн хангалтын нэг төрөл бөгөөд Хил хамгаалах байгууллагын анги, салбаруудыг инженерийн зэвсэглэл, хэрэгслээр цаг тухайд нь хангах/нөхөн

²⁰³ Д.Нямдорж, Улсын хилийг инженер техникийн хэрэгслээр хамгаалах аргыг боловсонгуй болгох нь. Докторын ажил

хангах/, тэдгээрийг зориулалтаар нь ашиглахад байнга бэлэн байлгах, цагийн байдлын янз бүрийн нөхцөлд ашиглалтын найдвартай ажиллагааг хангах, хилийн нэгтгэл, анги, салбаруудын өмнө тавигдсан алба-байлдааны үүргийг биелүүлэхэд шаардлагатай албаны өндөр бэлэн байдлыг богино хугацаанд хангахад нь дэмжлэг үзүүлэхийг хэлнэ.

Дүгнэлт

Хил хамгаалах байгууллага хуулиар хүлээсэн үүргээ чиг үүргээ хэрэгжүүлэхэд улсын хилийн инженер-техникийн хангалтыг цаг хугацаанд нь өндөр зохион байгуулалттайгаар хийж чанартай гүйцэтгэснээр улсын хилийг манах, хамгаалах иж бүрэн системд инженер-техникийн арга- хэмжээний эзлэх байр, гүйцэтгэх үүргийг оновчтой тодорхойлж, улсын хилийг манах хамгаалах орчин цагийн нэг гол арга болно гэдгийг бүхий л шатанд ойлгох, анхаарч хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Санал

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын дархан хил зорилтыг хэрэгжүүлж Хил хамгаалах байгууллага ”Цэрэг техникийн бодлого” удирдлагын баримт бичиг боловсруулан баталуулах, судалгааны ажлыг эрчимжүүлэх;

Мэдрэгчтэй шилэн кабелийг хилийн зөрчил гарч болзошгүй хилийн отряд, заставын хариуцсан хэсэгт суурилуулах;

Техник хэрэгслийн бүрэн шинэчлэлийг нэг дор хийх бололцоогүй байгаа тул бүсийн онцлогт тохируулан инженерийн байгууламжийн ашиглалтыг сайжруулах, нэмэгдүүлэх, дээшлүүлэхэд чиглүүлсэн олон талт арга хэмжээг зохион байгуулах.

Эх сурвалжийн жагсаалт:

-Улсын их хурал, Засгийн газрын тогтоол, бодлогын баримт бичиг:

Монгол Улсын Их хурлын 52 дугаар тогтоол Монгол Улсын урт хугацааны хөгжлийн хөтөлбөр “Алсын хараа 2050” (УИХ-ын тогтоол №52, 2020 он)

-Хууль тогтоомж:

Монгол Улсын Хилийн тухай хууль (2016)

-Ном сурах бичиг, гарын авлага:

А.Муратхан хил судлалын шинжлэх ухааныонол практикийн зарим асуудал

УБ, 2014 он

А.Энхтөр Монгол Улсын хилийн цэргийн байгуулалтын онол, практикийн асуудал УБ., 2021 он

Б.Түмэн, С.Ганбямба, Г.Ганзориг Опериац, байлдаанд цэргийн удирдлага УБ., 2021 он

Б.Лхагва Хилийн цэргийн ар тал хангалтын үйл ажиллагааны онол практикийн асуудал УБ., 2005 он

Д.Нямдорж, Улсын хилийг инженер техникийн хэрэгслээр хамгаалах аргыг боловсонгуй болгох нь. Докторын ажил